



**ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2017 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/146

Улаанбаатар хот

**Ёс зүйн хороог шинэчлэн  
байгуулах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9, 6.5.1. дэх заалт, Иргэний нисэхийн ерөнхий газрын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 3.11.1, 3.11.2, 3.11.3, 3.11.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ёс зүйн хэм хэмжээг байгууллагын ажилтнуудад мөрдүүлэх, гаргасан ёс зүйн зөрчлийг хороогоор хэлэлцэж, санамж, анхааруулга, дүгнэлт өгөх зорилгоор орон тооны бус “Ёс зүйн хороо”-г дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Хорооны дарга:	Б.Мөнхбат	Захиргаа, удирдлагын газрын захиргааны мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Б.Болор-Эрдэнэ	Агаарын харилцаа, агаарын тээвэрлэгчдийн үйл ажиллагааны зохицуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн
Гишүүд:	П.Цогбаяр	Дотоод аудитын албаны аудитор
	Ч.Одгэрэл	Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Б.Ганхуяг	Нисэх буудлуудын бодлого, зохицуулалтын хэлтсийн газрын үйлчилгээний ахлах мэргэжилтэн
	Д.Баясгалан	Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн албаны инженер-эдийн засагч
	Д.Дэлгэрсайхан	Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны Аэродром, агаарын навигацийн хяналтын хэлтсийн байцаагч

Д.Нямдаваа	Газрын тусгай үйлчилгээний албаны компьютер сүлжээ, камерын хяналтын инженер
Б.Цолмонтуяа	“Чингис хаан” Олон улсын нисэх буудлын Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

2. Ёс зүйн хорооны дүрмийг боловсруулан хорооны хурлаар хэлэлцүүлж, батлахыг Ёс зүйн хороо /Б.Мөнхбат/-нд даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2013 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/448 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА / Л.БЯМБАСҮРЭН

